



Оюу Толгой ХХК

Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны
удирдлагын тогтолцооны журам

Зэрлэг ан амьтан, ургамал болон тэдгээрийн гаралтай
бүтээгдэхүүнтэй холбоотой хууль бус үйлдлийн талаар мөрдөх
журам

Зэрлэг ан амьтан, ургамал болон тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүнтэй холбоотой хууль бус үйлдлийн талаар мөрдөх журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2014.06.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е9-PRC-0005-М	Хувилбар: 1.1

1. ЗОРИЛГО

Энэхүү журмын зорилго нь Өмнөговь аймгийн нутагт хууль бусаар зэрлэг ан амьтан агнах, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн, ургамлыг түүх, хадгалах аюулуудыг бууруулах зорилгоор Оюу Толгой компаний зүгээс хэрэгжүүлэх урьдчилан сэргийлэх болон сайжруулах стратегийг тодорхойлох юм. Уг стратегид одоо явуулж буй бүх үндсэн болон гэрээт ажилтнуудад зориулсан сургалтын хөтөлбөр, мөн бүх үндсэн болон гэрээт ажилтан, зочид зэрлэг ан амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүнтэй холбоотой хууль бус үйлдэл гаргасан тохиолдолд авах арга хэмжээ зэрэг багтана.

2. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү журам нь Оюу Толгой компаний бүх үндсэн болон гэрээт ажилтнууд, зочид компаний эзэмшилд байдаг, үйл ажиллагаа явуулдаг болон удирдлагад байдаг аливаа өмчид байх үе, мөн төслийн талбайгаас гадна Оюу Толгой компанитай хамааралтай ажил үүрэг гүйцэтгэх үеийг хамарна.

3. ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Албан тушаал	Үүрэг хариуцлага
Үндсэн ба гэрээт ажилтнууд, зочид	<ul style="list-style-type: none"> Оюу Толгой компаний эзэмшдэг, үйл ажиллагаа явуулдаг, удирддаг аливаа нэг өмчид байх үедээ эсвэл Оюу Толгой компанид хамааралтай ажил үүрэг гүйцэтгэх хугацаанд талбайн гадуур зөвшөөрөлгүй ан амьтан агнах, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн, ургамлыг түүх, хадгалах үйл ажиллагаанд оролцохгүй. Оюу Толгой компаний эзэмшлийн бүсэд хуулиар хориглосон зэрлэг ан амьтан, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн, ургамал авчрах буюу хадгалахгүй байх Энэхүү журмыг зөрчсөн буюу хууль бусаар зэрлэг ан амьтан, ургамал агнах болох түүх тохиолдлыг харсан/сонссон бол ахлах ажилтандаа даруй мэдээлэх Гэмтэж бэртсэн, үхсэн зэрлэг амьтны талаар мэдээлэх
Хамгаалалтын ажилтнууд	<ul style="list-style-type: none"> Ан амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүнийг хууль бусаар хадгалж буй тохиолдлыг илрүүлэх гэнэтийн үзлэг шалгалт явуулах Хууль бусаар ан амьтан агнасан, ургамал түүсэн, тэдгээрийг хадгалсан аливаа тохиолдлыг орон нутгийн цагдаад мэдээлэх

Зэрлэг ан амьтан, ургамал болон тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүнтэй холбоотой хууль бус үйлдлийн талаар мөрдөх журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2014.06.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е9-PRC-0005-М	Хувилбар: 1.1

4. ЖУРАМ

4.1. Хууль бусаар зэрлэг ан амьтан агнах, ургамал түүх, хадгалахыг хориглох тухай

Өмнөговийн бүс нутагт хууль бусаар зэрлэг ан амьтан агнах, ургамал түүх, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүнийг хууль бусаар эзэмшилдээ авах явдлыг Оюу Толгой компани хүлээн зөвшөөрөхгүй.

Оюу Толгой компаний үндсэн болон гэрээт ажилтнууд, зочид Оюу Толгой компаний эзэмшдэг, үйл ажиллагааг нь эрхлэн явуулдаг аливаа өмчид байх үедээ, эсвэл түүнээс гадуур Оюу Толгой компанитай хамааралтай ажил үүрэг гүйцэтгэж яваа үедээ ан амьтан агнах, ургамал түүх үйл ажиллагаанд оролцохыг хатуу хориглоно.

Хууль бусаар агнасан болон түүсэн зэрлэг ан амьтан, амьтны гаралтай бүтээгдэхүүн, ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнийг Оюу Толгойн эзэмшлийн бүсэд нэвтрүүлэхгүй.

Хууль бус зэрлэг ан амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн байгаа эсэхийг шалгах зорилгоор Оюу Толгой компаний эзэмшлийн бүсэд нэвтэрч буй аливаа ачаа бараа, сав баглаа зэрэгт үзлэг хийж болно.

4.2. Журмыг зөрчсөн тохиолдолд

Дараах үйл ажиллагаанд оролцсон нь тогтоогдсон үндсэн болон гэрээт ажилчид, зочдод хүний нөөцийн HR-H1.1 Гүйцэтгэлийн менежмент ба сахилгын журмыг баримтлан ажлаас халах хүртэлх сахилгын арга хэмжээ авч болно:

- Оюу Толгой компаний эзэмшдэг, үйл ажиллагааг нь эрхлэн явуулдаг аливаа өмчид байх үедээ, эсвэл түүнээс гадуур Оюу Толгой компанитай хамааралтай ажил үүрэг гүйцэтгэж яваа үедээ хууль бус болон хулгайн ан хийх
- Оюу Толгой компаний эзэмшлийн бүсэд хууль бус зэрлэг ан амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн хадгалах, эзэмших
- Оюу Толгой компаний эзэмшлийн бүс рүү хууль бусаар зэрлэг ан амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн нэвтрүүлэх буюу авч гарахыг оролдох
- Зэрлэг ан амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүний хууль бус наймаанд оролцох
- Хууль бус ан амьтан, амьтны гаралтай бүтээгдэхүүнийг түгээх, наймаалах, хадгалах, дамжуулах аливаа үйл ажиллагаанд оролцох, дэмжлэг үзүүлэх

Оюу Толгойн үндсэн ажилтнаас бусад этгээд энэхүү журмыг зөрчсөн тохиолдол гарвал тухайн ажил олгогч холбогдох сахилгын арга хэмжээг хариуцан авна. Оюу Толгой компаний зүгээс журмыг зөрчсөн этгээдийг компаний эзэмшлийн талбайгаас гаргах эрхийг эдэлнэ.

5. ТОДОРХОЙЛОЛТ

Зэрлэг ан амьтан: ховор эсэхээс үл хамааран амьд болон үхсэн зэрлэг амьтны бүтэн бие, түүж цуглуулсан байгалийн ургамлын төрөл зүйл.

Зэрлэг ан амьтны гаралтай бүтээгдэхүүн: зэрлэг ан амьтны боловсруулаагүй үс, арьс шир, ноос, ноолуур, эвэр, туурай, яс, мах, биеийн шингэн/цус, шувууны өд, хошуу, сарвуу, байгалийн ургамал, цэцэг, навч, мөчир, үндэс, үр, жимс.

Оюу Толгой компаний эзэмшлийн бүс: Оюу Толгой ХХК-ий удирдаж, хянадаг талбай.

Зэрлэг ан амьтан, ургамал болон тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүнтэй холбоотой хууль бус үйлдлийн талаар мөрдөх журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2014.06.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е9-PRC-0005-М	Хувилбар: 1.1

6. БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТ

Файлын нэр	ОТ-10-Е9-PRC-0005-М-Зэрлэг ан амьтан, тэдгээрийн бүтээгдэхүүн, ургамалтай холбоотой хууль бус үйлдлийн талаар мөрдөх журам_v1.1.docx
Тодорхойлолт	Зэрлэг ан амьтан, ургамал болон тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүнтэй холбоотой хууль бус үйлдлийн талаар мөрдөх журам
Анхны зохиогчид	Деннис Хосак
Үүсгэсэн огноо	2014.04.29
Баталсан	Марк Слэйтер
Баталсан огноо	2014.06.01
Өөрчлөлтийн бүртгэлийн дугаар	##

Эрсдэлийн зэрэг	Үнэлгээ хийсэн огноо	Эрсдэлийн үнэлгээ хийгч	Хянан засвар хийх хуваарь	Дараагийн хянан засвар хийх огноо
Дунд	2014.06.01	Деннис Хосак	2 жил тутам	2016.08.14

Хувилбар	Хянан засвар хийсэн огноо	Зохиогчид	Баталсан	Хянан засварын тэмдэглэл
1.0	2014.06.01	Деннис Хосак	Марк Слэйтер	Баталсан
1.1	2014.08.14	Деннис Хосак	Деннис Хосак	4.2-р заалтад хүний нөөцийн журмыг мөрдөх тухай оруулсан.